БАТЛАВ
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
Э.ЭНХЗОРИГ

БАТЛАВ
ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АГААРЫН ЦЭРГИЙН ШТАБЫН ДАРГА
ХУРАНДАА Б.ЭНХЗОРГОЛ

“ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨХХК БОЛОН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АГААРЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ ХООРОНДЫН ХАРИЛЦАН АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН ГЭРЭЭ

2026 оны 04 сарын 30 өдөр №24/103 Улаанбаатар хот

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Агаарын зайг нисэхэд ашиглах тухай Монгол Улсын хууль, Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хууль, Улсын нисэхийн тухай Монгол Улсын хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор нэг талаас “Иргэний нисэхийн үндэсний төв” ТӨХХК (“ИНҮТ” ТӨХХК) түүнийг төлөөлөн Агаарын навигацийн үйлчилгээний газрын дарга Д.Баяртогтох /цаашид “----------” гэх/, нөгөө талаас Агаарын цэргийн командлалын зэвсэгт хүчний агаарын цэргийн командлалын төв командын байлдааны жижүүрлэлтийн ахлах офицер, дэд хурандаа Д.Нямсүрэн (цаашид ..... гэх), хамтад нь “хоёр тал” гэх/ нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

1.2. Гэрээнд “Иргэний нисэхийн үндэсний төв” ТӨХХК-ийн Агаарын навигацийн үйлчилгээний газрын харьяа Иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба, Нисэхийн холбоо, навигаци, ажиглалтын алба, Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба, Нисэхийн урсгал төлөвлөлтийн албадууд агаарын навигацийн үйлчилгээ үзүүлэх ба тус гэрээгээр дээрх албадуудын хариуцах үйл ажиллагааг тусгасан болно.

1.3. Зохицуулалтын баримт бичгүүд

1.3.1. Энэхүү гэрээ нь дараах бичиг баримтыг үндэслэн боловсруулагдсан болно. Үүнд:
a) Агаарын зайг нисэхэд ашиглах тухай Монгол Улсын хууль
b) Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хууль
c) Улсын нисэхийн тухай Монгол Улсын хууль

1.4. Нэр томьёо тодорхойлолт

1.4.1. Энэхүү журамд “ИНД-ийн нэр томьёоны тайлбар”-т орсон нэр томьёо, тодорхойлолтуудыг ашиглана.

1.5. Товчилсон үгсийн тайлбар

ИНҮТ ТӨХХК	“Иргэний нисэхийн үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
АЦК	Агаарын цэргийн командлал

“ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨХХК ХЯНАВ Хуулийн мэргэжилтэн 3 2026 он 04 сар 29 өдөр

АБЧУГ	Аюулгүй байдал, чанарын удирдлагын газар
АНҮГ	Агаарын навигацийн үйлчилгээний газар
НХҮА	Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба
НМҮА	Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба
НХНАА	Нисэхийн холбоо, навигаци, ажиглалтын алба
НЖЗШНА	Нислэгийн журам зохиолт, шалгалтын нислэгийн алба
НУТА	Нислэгийн урсгал, төлөвлөлтийн алба
БҮҮХ	Бүсийн удирдлагын үйлчилгээний хэсэг
ОҮҮХ	Ойртолтын удирдлагын үйлчилгээний хэсэг
АҮҮХ	Аэродромын удирдлагын үйлчилгээний хэсэг
НМАДМҮХ	Нислэгийн мэдээлэл, аюулын дохио мэдээллийн үйлчилгээний хэсэг
ЭЕНХУ	Ээлжийн Ерөнхий нислэгийн хөдөлгөөний удирдагч
НМТ	Нислэгийн мэдээллийн төв
НХЗБ	Нислэгийн хөдөлгөөн зохицуулах бүлэг;
АУБ	Аэродромын удирдлагын байр
ИНД	Иргэний нисэхийн дүрэм
УНД	Улсын нисэхийн дүрэм
ЦАЕН	Цаг агаарын ердийн нөхцөл
ЦАХН	Цаг агаарын хүндэрсэн нөхцөл
НХБ	Нислэгийн холбооны бүлэг
АА	Ардын арми
ЗХ	Зэвсэгт хүчин
АІР	Нисэхийн мэдээллийн эмхэтгэл
НМАБ	Нислэгийн мэдээллийн ажлын байр
ОУНБ	Олон улсын нисэх буудал
УНХ	Улсын нисэхийн хэсэг
НУТ	Нислэг удирдах тасаг
НЦХЗХ	Нислэгийн цагийн хуваарь, зөвшөөрлийн хэсэг
ШТХ	Шуурхай төлөвлөлтийн хэсэг
ХНХ	Хилийн нисэх хэсэг
НМҮ	Нисэхийн мэдээллийн үйлчилгээ
ТМХ	Тогтмол мэдээллийн хэсэг
ЗБТ	Зургийн боловсруулалтын тасаг
ТМБТ	Тогтмол мэдээллийн боловсруулалтын тасаг
ШМХ	Шуурхай мэдээллийн хэсэг
ТоМХ	Тоон мэдээллийн хэсэг
ICAO	Олон улсын иргэний нисэхийн байгууллага
UTC	Coordinated universal time

ХОЁР. АГААРЫН НАВИГАЦИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ҮҮРЭГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ХАРИУЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1.1. Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх болон улсын хилийг агаарын хаалгаар нэвтрэн өнгөрөх журмыг зөрчсөн, түүнчлэн эрх бүхий байгууллагын зохих зөвшөөрөлгүй улсын хил нэвтэрсэн агаарын хөлгийн талаар НХЗБ-ийн Нислэгийн хөдөлгөөний зохицуулагчид нэн даруй мэдэгдэнэ.

2.1.2. НХҮА-ны НХҮ-ний ажилтан нь нислэгийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор агаарын хөлгийг батлагдсан агаарын замаас гаргах, маршрут өөрчлөх /үүл тойрох,

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ"
ТӨХХК
ХЯНАВ
Хуулийн мэргэжилтэн З
2026 оны 04 сар 29 өдөр

агаарын замаас хазайх, чиглэл өгөх/ тохиолдолд НХЗБ-ийн Нислэгийн хөдөлгөөний зохицуулагчид яаралтай мэдээлнэ.

2.1.3. НХҮА-ны “Арцат” НМАБ-аас НХЗБ-ийн Нислэгийн хөдөлгөөний зохицуулагч зайлшгүй шаардлагатай тохиолдолд орон нутагт нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн мэдээллийг авна.

2.1.4. НХҮА-ны “Арцат” НМАБ-ны ажилтан нь Монгол Улсын агаарын зайд үйлдэх Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн нислэгүүдэд НХҮ-ний аюулгүй байдлыг хангуулахад шаардлагатай бусад мэдээллийг НХЗБ-ийн Нислэгийн хөдөлгөөний зохицуулагчтай солилцон, зөвшилцөж харилцан ажиллана.

2.1.5. НХҮА-ны “Арцат” НМАБ-ны ажилтан нь хилийн бүсэд нислэг үйлдэж байгаа Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн агаарын хөлгийн мэдээллийг НХЗБ-ийн Нислэгийн хөдөлгөөний зохицуулагчаас авч хамтран ажиллана.

2.1.6. Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн агаарын хөлөг Хяналттай агаарын зайд эрэн хайх, авран туслах зорилготой нислэг үйлдэж байвал зохих тусламж дэмжлэгийг үзүүлнэ.

2.1.7. Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн нислэг агаарт хөөрсний дараа тухайн агаарын хөлгийн нислэгийн зам дагуу болон үйл ажиллагаа явуулж байгаа бүс орчимд зарлагдсан хязгаарлалтай, аюултай болон хилийн бүс дэх нислэгийн талаарх мэдээлэл, цэргийн байгууллагын зүгээс хийгдэж буй нислэг, буудлага үйлдэж байгаа газар орны талаарх мэдээллийг дамжуулна.

2.1.8. Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн агаарын хөлгүүдэд НХҮА-ны нэгжүүд хариуцлагын бүсүүдэд НХҮ-г үзүүлнэ.

2.1.9. МиГ-29УБ агаарын хөлгүүд “Буянт-Ухаа” АУБ-ны удирдлагын зоонд, “Улаанбаатар” ойртолтын удирдлагын бүсэд сургууль, дадлагын нислэг, “Буянт-Ухаа” ОУНБ болон М-808, М-818 бүс хооронд маршрутын нислэг үйлдэх үед НХҮ явуулж байгаа НХҮА-ны нислэгийн хөдөлгөөний удирдагч нь Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн НУТ-аас НХҮА-нд томилогдон ажиллаж байгаа нислэгийн удирдагчтай зөвшилцөн хамтран ажиллана.

2.1.10. МиГ-29УБ агаарын хөлөг М-808 бүсээс “Буянт-Ухаа” ОУНБ-руу нисэн ирж байгаа үед хүлээлгэх шаардлага үүсвэл боломжтой бол М-808 бүс дотор хүлээлгэхээр Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн НУТ-ын нислэгийн удирдагчтай зөвшилцөх, НХҮА-ны нислэгийн хөдөлгөөний удирдагчийн удирдлагад орсон бол Гачуурт болон Чингэлтэй цэгийн хооронд баруун эргэлтээр өндрийг нь хадгалуулан хүлээлгэнэ.

2.1.11. МиГ-29УБ агаарын хөлөгт нислэгийн онцгой тохиолдол үүссэн үед Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн НУТ-аас НХҮА-нд томилогдон ажиллаж байгаа нислэгийн удирдагч нь НХҮА-ны нислэгийн хөдөлгөөний удирдагчид шаардлагатай тусламжийг үзүүлнэ.

2.1.12. НХҮА-ны нислэгийн өмнөх ярианд оролцож байгаа Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн нислэгийн удирдагч нь тухайн өдөр нислэг үйлдэх МиГ-29УБ агаарын

ХЯНАВ
Хуулийн мэргэжилтэн 3
2026 оны 04 сарын 29 өдөр

хөлгүүд буултын дараа хурд сааруулах шүхэр хэрэглэх тухай мэдээлэл өгсөн бол буулт үйлдэж байгаа агаарын хөлгийг буултын дараа ажиглан шүхэр задрахгүй, эсхүл шууд хаягдах гэх мэт дутагдал харагдвал Зэвсэгт хүчний 337 дугаар англйн нислэгийн удирдагчийн зөвлөмжийн дагуу радио холбоогоор "шүхэр шүхэр шүхэр" гэж нисэх багт анхааруулна.

2.1.13. НХҮА-ны НМАДМҮХ нь эрэн хайх, авран туслах үйл ажиллагааны үед аюул тулгарсан эсхүл аюулд нэрвэгдсэн агаарын хөлгийн талаарх шаардлагатай мэдээллийг (Радиолокацийн хяналт болон аюул тулгарсан эсхүл аюулд нэрвэгдсэн агаарын хөлгийн байрлалыг тогтоох г.м) Зэвсэгт хүчний 337 дугаар англйн НУТ-т шуурхай мэдээлнэ.

2.1.14. Буянт-Ухаа ОУНБ болон Чингис Хаан ОУНБ-аас бусад аэродромоос нисэн гарах нислэгийн төлөвлөгөөг НХҮА-ны нэгжээр дамжуулна.

2.2. НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБАНЫ ХАРИУЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.2.1. НУТА-ын НЦХЗХ-ийн нислэгийн урсгал төлөвлөлтийн мэргэжилтэн нь батлагдсан олон улсын хөөрөлт, буултын болон орон нутгийн "Урьдчилсан төлөвлөлтийн нислэгийн мэдээ"-г ажлын өдрийн 18:00 цагт багтаан дараах нэгжүүдийн цахим хаягт тус тус хүргүүлнэ. Үүнд:

a) НУТ-ийн Нислэгийн удирдагчид b.shdanzan@gmail.com
b Агаарын цэргийн төв командын жижүүрт chuluut@mil.gov.mn
c) НХЗБ-ийн Нислэгийн хөдөлгөөний зохицуулагчид menen_1@mil.gov.mn

2.2.2. НУТА-ын ШТХ нь олон улсын хөөрөлт, буултын болон орон нутгийн нислэгийн гүйцэтгэлийг 7 хоногоор гарган НХЗБ-ийн Нислэгийн хөдөлгөөний зохицуулагчид файл хэлбэрээр menen_1@mil.gov.mn цахим хаягаар хүргүүлнэ.

2.2.3. НУТА-ын ШТХ-ийн нислэгийн төлөвлөлтийн ээлжийн мэргэжилтэн нь олон улсын өнгөрөлтийн хоногийн нислэгийн төлөвлөгөөг тухайн өдрийн өглөөний ээлжийн өмнөх зааварчилга яриан дээр НХЗБ-ийн Нислэгийн хөдөлгөөний зохицуулагчид дараах мэдээллийг өгнө.Үүнд:

a) "Урьдчилсан төлөвлөлтийн нислэгийн мэдээ"-нд тусгагдсан онцгой үүрэг, албан захиалгат болон тусгай үүргийн нислэгийн талаарх мэдээлэл;
b) Олон улсын өнгөрөлтийн нислэгийн мэдээлэл;
c) Бусад

2.2.4. ШТХ-ийн Нислэгийн төлөвлөлтийн ээлжийн мэргэжилтэн нь шуурхайгаар төлөвлөлтөд тусгагдсан олон улс, орон нутгийн нислэгийн өөрчлөлт, саатал, цуцлалтын мэдээлэл болон шинээр нэмэгдэж байгаа нислэгийн талаар НХЗБ-ийн Нислэгийн хөдөлгөөний зохицуулагчид тухай бүр 71-281629 утсанд танилцуулна.

2.2.5. Улсын агаарын хөлгийн онцгой болон тусгай үүргийн нислэгийн төлөвлөгөө, төлөвлөгөөний өөрчлөлтийг fpd@mcaa.gov.mn, tpu@mcaa.gov.mn цахим хаягаар тус тус хүлээн авна.

2.2.6. НУТА-ны үйл ажиллагаатай холбоотой баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд өөрчлөлтийг албаны цахим шуудан болон Web хуудсаар мэдээлнэ.

...ний нисэхийн үндэсний төв"
ТӨХХК
ХЯНАВ
Хуулийн мэргэжилтэн 3
2026 оны 04 сарын 29 өдөр

2.2.7. Нислэгийн урсгал төлөвлөлтийн урьдчилсан болон шуурхай төлөвлөлтийн мэдээллээр хангахад ХНХ-ийн Нислэгийн үйл ажиллагаа хариуцсан офицертой дараах холбоо барих хаяг, хэрэгслийг ашиглан харилцан ажиллана. Үүнд:

а) Холбоо барих утас /АЦК-аас тодруулж авах/
а) Цахим шуудан /АЦК-аас тодруулж авах/

2.2.8. ATFMS сүлжээний бэлэн байдал болон програм хангамжтай холбоотой асуудлыг хариуцна.

2.2.9. НХЗБ-ийн Нислэгийн хөдөлгөөний зохицуулагчийг ATFMS сүлжээгээр дамжуулан "Өдрийн төлөвлөлт" болон "Урьдчилсан төлөвлөлтийн нислэгийн мэдээ" түүнд орсон нислэгийн өөрчлөлт болон шинээр төлөвлөгдсөн хуваарьт бус нэмэгдэл нислэгийн мэдээллээр хангана.

2.3. НИСЭХИЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АЛБАНЫ ХАРИУЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.3.1. Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалаас томилогдсон ажилтнуудаас хүлээн авсан түүхий өгөгдлийн дагуу тохирох нисэхийн мэдээллийн бүтээгдэхүүнийг хэвлэн нийтэлнэ.

2.3.2. НМҮА нь Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ийн Doc 4444-ийн Нэмэлт хавсралт 2-ын дагуу бөглөж, нислэгийн төлөвлөгөө (FPL)-г цахим шуудангийн aiszmub@ncac.mn хаягаар болон ais.mn цахим хуудасны Internet self-briefing хаягуудаар хүлээн авах бөгөөд нислэгийн хөдөлгөөний холбогдолтой мэдээ (FPL, DEP, DLA, ARR, CHG, CNL)-г AFS сүлжээгээр дамжуулна.

2.3.3. НМҮБ-д ашиглагдах "Түүхий өгөгдөл хүлээн авах маягт" МА-ЖУ2-1 болон түүнд орсон өөрчлөлт, нэмэлтийг Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалаас томилогдсон ажилтнуудад цахим шуудангаар хүргүүлнэ.

2.3.4. Нисэхийн өгөгдлийн чанарын шаардлага (цагийн хязгаар/timeliness) хангаагүй түүхий өгөгдөл ирүүлсэн тохиолдолд нисэхийн мэдээллийн бүтээгдэхүүн хэвлэн нийтлэхгүй байх эрхтэй.

2.3.5. Нисэхийн өгөгдлийн чанарын шаардлага (цагийн хязгаар/timeliness) хангасан түүхий өгөгдөл хүлээн авсан ч зохих цаг хугацаанд нь нисэхийн мэдээллийн бүтээгдэхүүн хэвлэн нийтлээгүйгээс үүсэх хариуцлага хүлээнэ.

2.3.6. Агаарын цэргийн командлалаас томилогдсон ажилтнуудаас хүлээн авсан түүхий өгөгдлөөс зөрүүтэй, алдаатай нисэхийн мэдээллийн бүтээгдэхүүн хэвлэн нийтэлсэн тохиолдолд хариуцлага хүлээнэ.

2.3.7. НМҮБ-д ашиглагдах "Түүхий өгөгдөл хүлээн авах маягт" МА-ЖУ2-1 болон түүнд орсон өөрчлөлт, нэмэлтийг Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалаас томилогдсон ажилтнуудад цахим шуудангаар хүргүүлнэ.

2.4. НИСЭХИЙН ХОЛБОО, НАВИГАЦИ, АЖИГЛАЛТЫН АЛБАНЫ ХАРИУЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.4.1. Хугацаат техник үйлчилгээ болон, сэлгэн залгалтын үед АЦК-ын цахилгаан хангалтын үйлчилгээнд тасалдал үүсгэхээр бол урьдчилан мэдэгдэнэ.

нисэхийн үндэсний төв"
ТӨХХК
ХЯНАВ
Хуулийн мэргэжилтэн З
2026 оны 04 сарын 29 өдөр

2.4.2. НХНАА-ны батлагдсан техник үйлчилгээний хуваарийн дагуу АЦК-ын цахилгааны ерөнхий оруулгын самбарт (ТП-6 дэд өртөөний 0,4кВ-ын хуваарилах байгууламж) хугацаат техник үйчилгээг хийнэ.

2.4.3. Эрчим хүчний хэрэглээний тооцоог хийж нэхэмжлэлийг хүргүүлнэ.

2.4.4. Нисэхийн холбоо, навигаци, ажиглалтын алба (НХНАА)-ны Богд-Уулан дахь хэт богино долгионы байрны гадна талбай болон түүний хамгаалагдсан бүсийн хамгаалалтын хашааг хамгаалах, хяналт тавих үүрэг хүлээнэ

2.5. БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ЧИГЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.5.1. Нисэхийн холбоо, навигаци, ажиглалтын алба нь өөрийн эзэмшлийн Богд-Уулан дахь хэт богино долгионы байртай холбоотой үйл ажиллагааг дараах байдлаар зохицуулна. Үүнд:

2.5.1.1. Өөрийн байрлуулсан тоног төхөөрөмж дээр ажиллахдаа холбогдох бичиг баримт, зөвшөөрлөө станцын ахлах инженерт үзүүлж станцын байр руу саадгүй нэвтрэх эрхтэй.

2.5.1.2. Нисэхийн холбоо, навигаци, ажиглалтын албаны телефон дугаар болон телефон утасны үзүүр хүртлэх, цахилгааны тэжээлийн бэлэн байдлыг хангах үүрэгтэй.

2.5.1.3. Мотор, тень зэрэг халах төхөөрөмж байрлуулсан тохиолдолд гарч болох галын аюулаас урьдчилан сэргийлж, технологийн дагуу суурилуулах бөгөөд амархан халах, шатах материалаас хол бусад тоног төхөөрөмжид нөлөө үзүүлэхгүй байхуйц зайнд байрлуулах ба техникийн хүчин чадалд нь тохирсон аюулгүйн шаардлага хангасан залгуур ашиглана.

2.5.1.4. Мотороос хөргөлтийн болон халаагуур хүртэлх залгуур утсыг технологийн дагуу монтажилж галын аюулаас сэргийлэх, цахилгаан төхөөрөмжийн болон ажлын байрны аюулгүй ажиллагааг мөрдөх үүрэг хүлээнэ.

2.5.1.5. Тоног төхөөрөмж нэмж байрлуулах, татан буулгах үед бусад техник, төхөөрөмжийн хэвийн ажиллагааг алдагдуулахгүй байх ба хэрэв өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас байр талбайд байрлах бусад тоног төхөөрөмжид эвдрэл, гэмтэл саатал учруулбал учирсан хохирлыг арилгах үүрэгтэй.

2.5.1.6. Богд-Уулын хэт богино долгионы байр талбайд байршуулсан өөрийн тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг хариуцан ажиллах үүрэгтэй.

ГУРАВ. АГААРЫН ЦЭРГИЙН КОМНАДЛАЛЫН ХАРИУЦАХ ҮҮРЭГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

3.1.1. Улсын агаарын хөлгийн онцгой болон тусгай үүргийн нислэг үйлдэх бол нислэгийн мэдээллийг Нислэгийн урсгал төлөвлөлтийн албаны fpd@mcaa.gov.mn; болон tpu@mcaa.gov.mn цахим хаягаар илгээж, нислэгийн хүсэлтийг хүлээж авсан эсэхийг 71-282235, 71-281602 дугаарын утсаар баталгаажуулан, нислэг үйлдэнэ.

3.1.2. Сургууль-дадлагын нислэгийг зохион байгуулах тохиолдолд нислэг үйлдэхээс өмнөх өдөр нь НУТА-нд урьдчилан мэдэгдэнэ.

"ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨХХК
ХЯНАВ
Хуулийн мэргэжилтэн 3
2026 он 04 сар 29 өдөр

3.1.3. Нислэгийн өөрчлөлт, цуцлалтын аливаа мэдээллийг НУТА-ны ШТХ-ийн Нислэгийн төлөвлөлтийн ээлжийн мэргэжилтэнд /71-281602 утсанд/ шуурхай дамжуулна.

3.1.4. Монгол Улсын хил болон хилийн агаарын бүсэд нислэг үйлдэх тохиолдолд Монгол Улсын Хилийн тухай хууль, Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль, Монгол–Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол-БНХАУ-ын Засгийн газар хоорондын гэрээ, Орос–Монголын хилийн дэглэмийн тухай гэрээ, холбогдох бусад дүрэм, журам болон "Нислэгийн хөдөлгөөнийг төлөвлөх, зөвшөөрөл олгох журам"-ыг мөрдлөг болгоно.

3.1.5. Дархан цаазат газарт нислэг үйлдэх тохиолдолд Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг дагаж мөрдөнө.

3.1.6. Улсын агаарын хөлгөөр арилжааны нислэг үйлдэх тохиолдолд Иргэний нисэхийн тухай хуулийн дагуу үйлдэнэ.

3.1.7. Монгол Улсын хилийн агаарын бүс болон дархан цаазат газарт амралт, баяр ёслолын өдрүүдэд эсхүл ажлын бус цагаар нислэг үйлдэх тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийг тухайн нислэг үйлдснээс хойш хамгийн эхний ажлын өдрийн 16:00 цагаас өмнө НУТА-д нөхөж ирүүлнэ.

3.2. НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

3.2.1. Зэвсэгт хүчний Агаарын цэргийн Төв командын байрны НХЗБ-ийн Нислэгийн хөдөлгөөний зохицуулагч нь тухайн өдрийн нислэгийн өмнөх зааварчилга ярианд оролцож нислэгийн урьдчилсан төлөвлөлт, түүний явц, орон нутгийн болон "Буянт-Ухаа" ОУНБ-ын аэродром, техник тоног төхөөрөмж, цаг агаар, навигацийн төхөөрөмжийн ашиглалтын байдлын талаарх мэдээллүүдтэй танилцана.

3.2.2. НХЗБ-ийн Нислэгийн хөдөлгөөний зохицуулагч нь ээлжийн өмнөх зааварчилга ярианд Монгол Улсын нутаг дэвсгэрт хязгаарлалттай, хориотой, аюултай болон хилийн бүс дэх нислэгийн талаар мэдээлэл өгөх ба цэргийн байгууллагын зүгээс хийгдэж буй нислэг, буудлагын талаар танилцуулж, ээлжийн өмнөх зааварчилга ярианы дэвтэрт тэмдэглэгээ хийж, гарын үсгээр баталгаажуулна.

3.2.3. Иргэний агаарын хөлөг цэргийн хориотой байгууламж, аюултай бүсэд ойртох буюу нэвтрэн орсон тохиолдолд НХЗБ нь НХҮА-нд анхааруулан шуурхай мэдэгдэнэ.

3.2.4. Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх болон улсын хилийг агаарын хаалгаар нэвтрэн өнгөрөх журмыг зөрчсөн, түүнчлэн эрх бүхий байгууллагын зохих зөвшөөрөлгүй улсын хил нэвтэрсэн агаарын хөлгийн талаар НХҮА-ний ЭЕНХУ-д мэдээлнэ.

3.2.5. НХЗБ-ийн Нислэгийн хөдөлгөөний зохицуулагч нь ажлын байраа түр орхих тохиолдолд ЭЕНХУ-д мэдэгдэх ба шаардлагатай үед холбоо тогтоох хаяг, байршил, бусад мэдээллийг урьдчилан мэдэгдэнэ.

3.2.6. НХЗБ-ийн Нислэгийн хөдөлгөөний зохицуулагч нь Монгол Улсын агаарын зайд явагдаж буй агаарын хөлгүүдийн нислэгт хяналт тавина.

"ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨХХК
ХЯНАВ
Хуулийн мэргэжилтэн З
2026 оны 04 сарын 29 өдөр

3.2.7. НХЗБ-ийн Нислэгийн хөдөлгөөний зохицуулагч нь эрэн хайх, авран туслах үйл ажиллагааны үед шаардлагатай мэдээллийг (Радиолокацийн хяналт болон аюул тулгарсан эсхүл аюулд нэрвэгдсэн агаарын хөлгийн байрлалыг тогтоох г.м) Эрэн хайх, авран туслах мэдээлэл зохицуулах хэсэгт шуурхай мэдээлнэ.

3.2.8. Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээтэй холбоотой гарсан зөрчил, дутагдлын талаарх мэдээллийг ИНҮТ-ийн АБЧУГ-т цаг тухайд нь хүргүүлж байна.

3.2.9. Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал НХҮА-тай хамтран нэг удаа нислэг удирдлагын чиглэлээр харилцан ажиллах, туршлага солилцох байдлаар харилцан сургалт /семинар/ зохион байгуулж явуулна.

3.3. НИСЛЭГИЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

3.3.1. “Урьдчилсан төлөвлөлтийн нислэгийн мэдээ” болон Нэмэгдэл нислэгийн мэдээнд тусгагдсан Буянт-Ухаа ОУНБ болон Чингис Хаан ОУНБ-аас нисэн гарах нислэгийн (FPL)-г Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ийн Doc 4444-ийн Нэмэлт хавсралт 2-ын дагуу бөглөж, цахим шуудан эсхүл ais.mn цахим хуудасны Нислэгийн өмнөх мэдээлэл цэсний Flight plan form-ыг ашиглаж нислэг эхлэхээс 30 минутаас багагүй хугацааны өмнө дамжуулан, "Буянт-Ухаа" ОУНБ-ын 71287283 болон “Чингис Хаан” ОУНБ-ын 71287280 дугаарын утсаар хүлээн авсан эсэхийг баталгаажуулна.

3.3.2. Чингис хаан ОУНБ болон Буянт-Ухаа ОУНБ-аас нисэн гарах захиалагчийн нислэг нь төлөвлөгдсөн цагаасаа 30 минутаас дээш хугацаагаар саатах тохиолдолд урьдчилж саатлын шалтгаан, саатал үргэлжлэх хугацааг гүйцэтгэгчид 71287280 болон 71287283 дугаарын утсаар мэдэгдэнэ.

3.3.3. Нислэг эхлэхээс өмнө хүчин төгөлдөр НМЭ-тэй танилцсан байх ба мэдээлэлтэй танилцаагүй тохиолдолд нисэх баг хариуцна. НМҮА нь ”Урьдчилсан төлөвлөлтийн нислэгийн мэдээ” -нд тусгагдсан Буянт-Ухаа ОУНБ болон Чингис Хаан ОУНБ-аас нисэн гарах нислэгт зориулан Нислэгийн өмнөх мэдээллийн товхимол (НӨМТ)-г нислэг эхлэхээс 2 цагийн өмнө, нэмэгдэл нислэгийн (НӨМТ)-г цаг тухайд нь бэлтгэн www.ais.mn цахим хуудсанд байршуулна.

3.3.4. Монгол Улсын AIP-ын ENR 5.2-т хэвлэн нийтлэгдсэн цэргийн дадлага сургуулилтын бүсийг идэвхжүүлэх түүхий өгөгдлийг НМҮБ-ын Raw Data программ (https://rawdata.ais.mn/)-аар хүргүүлж, 71285514 дугаарын утсаар баталгаажуулна. Түүхий өгөгдөл нь дараах шаардлагуудыг хангасан байна:

- ИНД-71 дүрмийн дагуу тогтоосон цэргийн үйл ажиллагааны бүсийг идэвхжүүлэх тохиолдолд уг бүс идэвхжихээс 24 цагаас доошгүй цагийн өмнө хүргүүлсэн байх.
- Түүхий өгөгдөлд бүсийн нэр, идэвхжих хугацаа (эхлэх хугацаа, дуусах хугацаа, тусгай цагийн хуваарь) доод, дээд хязгаар зэргийг заавал тусгасан байх.

3.3.5. Зэвсэгт хүчний Агаарын цэргийн Улсын агаарын хөлгөөр цэргийн дадлага сургуулилтын бүсрүү болон агаарын довтолгооноос хамгаалах бүсрүү байлдааны үүргийн болон сургууль дадлагын нислэг үйлдэх , түр цэргийн дадлага сургуулилт, буудлагын бүсийг идэвхжүүлэх гэх мэт Монгол Улсын AIP-ын ENR 5.2-т хэвлэн

ХЯНАВ
Хуулийн мэргэжилтэн 3
2026 он 04 сар 29 өдөр

нийтлэгдсэн цэргийн дадлага сургуулилтын бүсийг идэвхжүүлэхээс бусад түр шинж чанартай өгөгдлүүдийг ажлын цагаар (08:00-17:00) “ИНҮТ” ТӨХХК-д албан бичгээр хүргүүлнэ. Түүхий өгөгдөл нь дараах шаардлагуудыг хангасан байна:

- Түүхий өгөгдлийг эхлэх хугацаанаас 24 цагаас багагүй хугацааны өмнө хүргүүлсэн байх
- НМҮБ-ын “Түүхий өгөгдөл хүлээн авах маягт” МА-ЖУ2-1-ийг ашигласан байх
- Бүсийг газар зүйн солбицлуудаар илэрхийлэх тохиолдолд газар зүйн солбицлуудыг цагийн зүүний дагуу градус, минут, секундээр жагсааж оруулсан байх.
- Бүсийн босоо хязгаарыг оруулахдаа хэмжих нэгж, өгөгдөхүүн буюу хаанаас тооцсон өндөр болохыг илэрхийлэх AMSL (above mean sea level) эсхүл AGL (above ground level) товчлолыг оруулсан байх.
- Бүсийн доод хязгаар нь газрын гадарга байх тохиолдолд GND (ground), дээд хязгаар нь хязгааргүй тохиолдолд UNL (unlimited) товчлолуудыг хэрэглэсэн байх.
- Эхлэх, дуусах болон тусгайлан заасан хугацаа

3.3.6. Агаарын цэргийн командлалаас томилогдсон ажилтнуудаас хүлээн авсан түүхий өгөгдлөөс зөрүүтэй, алдаатай нисэхийн мэдээллийн бүтээгдэхүүн хэвлэн нийтэлсэн тохиолдолд хариуцлага хүлээнэ.

3.4. НИСЭХИЙН ХОЛБОО, НАВИГАЦИ, АЖИГЛАЛТЫН АЛБАНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

3.4.1. Эрчим хүчний хэрэглээний төлбөрийг нэхэмжлэлийн дагуу хугацаанд нь шилжүүнэ.

3.5. БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ЧИГЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.5.1. Зэвсэгт хүчний 303 дугаар анги нь Нисэхийн холбоо, навигаци, ажиглалтын албаны эзэмшлийн Богд-Уулан дахь хэт богино долгионы байранд нэмэлт төлбөргүй байрлаж, дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

3.5.1.1. Нисэхийн холбоо, навигаци, ажиглалтын алба (НХНАА)-ны Богд-Уулан дахь хэт богино долгионы байрны гадна талбай болон түүний хамгаалагдсан бүсийн хамгаалалтын хашааг хамгаалах хяналт тавих үүрэг хүлээнэ.

3.5.1.2. Нисэхийн холбоо, навигаци, ажиглалтын албаны Богд-Уулан дахь хэт богино долгионы байрны гадна талбай болон түүний хамгаалагдсан бүсийн хамгаалалтын хашаа, шилэн кабелийн байгууламжид гарсан эвдрэл гэмтлийг илрүүлсэн тохиолдолд яаралтай 7128-1603, 7128-1604, 7128-1605 дугааруудад 24 цагийн дотор шуурхай мэдэгдэх арга хэмжээг авна.

3.5.1.3. Нисэхийн холбоо, навигаци, ажиглалтын албаны Богд-Уулан дахь хэт богино долгионы байрны гадна талбай болон түүний хамгаалагдсан бүсийн хамгаалалтын хашаа болон тоног төхөөрөмж байршиж буй байр талбайн аюулгүй байдлыг хариуцан ажиллах ба хэрэв өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас байр талбайд байрлах бусад тоног төхөөрөмжид эвдрэл, гэмтэл саатал учруулбал учирсан хохирлыг арилгах үүрэгтэй.

“ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨХХК
ХЯНАВ
Хуулийн мэргэжилтэн 3
2026. оны 04 сар 29 өдөр

3.5.1.4. Мотор, тень зэрэг халах төхөөрөмж байрлуулсан тохиолдолд гарч болох галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна.

3.5.1.5. Зэвсэгт хүчний 303 дугаар анги нь нэмэлтээр мотор, тень, нэмэлт холбооны тоног төхөөрөмж зэрэг төхөөрөмжүүд байрлуулах тохиолдолд Нисэхийн холбоо, навигаци, ажиглалтын албатай хамтарч зөвшилцсөний үндсэн дээр суурилуулалтыг хийнэ.

3.5.1.6. Тус байгууллагын цахилгаан эрчим хүчний хэрэглээг тооцох тоолуур болон түүнээс цааших хэрэглэгчийн цахилгаан хангамжийн шугам сүлжээний ашиглалтыг хариуцна. Өөрийн хариуцах заагт хамаарах тоног төхөөрөмж шугам сүлжээнд засвар үйлчилгээ, өөрчлөлт хийхээр хангагч талаас таслуулах шаардлага гарсан тохиолдолд НХНАА-ны цахилгааны ээлжийн инженер (7128-1648)-т хандаж шийдвэрлүүлнэ.

ДӨРӨВ. ИРГЭНИЙ АГААРЫН ХӨЛГИЙГ АЛБАДАН СААТУУЛАХ ҮЕИЙН АЖИЛЛАГАА

4.1. Зөрчил гаргасан, эсхүл танигдаагүй иргэний агаарын хөлгийг батлан хамгаалах салбараас албадан саатуулах тохиолдолд НХҮА ба НХЗБ нь хоорондоо шуурхай холбоотой ажиллаж, мэдээлэл солилцон, уг агаарын хөлгийг таних, эсхүл зөрчлийг нь таслан зогсоох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.2. Батлан хамгаалах салбараас иргэний агаарын хөлгийг албадан саатуулахдаа ИНД-91-ийн Хавсралт В-г мөрдлөг болгон ажиллана.

4.3. НХЗБ ба НХҮА нь хориотой, хязгаарлалттай бүсэд ойртсон буюу нэвтэрсэн иргэний агаарын хөлгийг шуурхай тодорхойлж таних, хориотой бүсээс холдуулах навигацийн дэмжлэг туслалцааг харилцан ажиллаж үзүүлнэ.

4.4. НХЗБ нь иргэний агаарын хөлгийг албадан саатуулах үйл ажиллагааны талаар НХҮА-нд шуурхай мэдэгдэнэ.

4.5. НХҮА нь агаарын хөлөг албадан саатуулагдсан талаарх мэдээллийг авсан даруйдаа тухайн нөхцөлд нь тохируулж дараах арга хэмжээг авна:

a) албадан саатуулагдсан агаарын хөлөгтэй хоёр талын холбоо, түүний дотор 121.5 МГц ослын давтамж дээр холбоо тогтоохыг оролдох;
b) агаарын хөлгийн нисэх багт агаарын хөлөг албадан саатуулагдсан талаар нь мэдээлэх;
c) агаарын хөлгийг албадан саатуулж байгаа Агаарын цэргийн командлал /цаашид АЦК/, НХЗБ-тэй холбоо тогтоож агаарын хөлгийн талаар мэдээлэл солилцох;
d) албадан саатуулагдсан агаарын хөлөг ба албадан саатуулж байгаа байгууллага хоорондмэдээлэл дамжуулахад туслах;
e) агаарын хөлгийг албадан саатуулсан байгууллагатай нягт холбоотой ажиллаж аюулгүй ажиллагааг алдагдуулахгүй байх бүхий л арга хэмжээг авах;
f) хэрэв албадан саатуулагдсан агаарын хөлөг нь зэргэлдээх Нислэгийн мэдээллийн районоос буюу хөрш улсаас нэвтрэн орж ирсэн бол уг бүсийг хариуцаж байгаа НХҮ-ний байгууллага, нэгжид шуурхай мэдээлэх.

"ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ҮЙ" ХХК
ХЯНАВ
Хуулийн мэргэжилтэн 3
20 . . . он . . .сар . . . өдөр

ТАВ. БУСАД

5.1. Хяналт ба хариуцлага

5.1.1. ИНҮТ ТӨХХК-ийн Аюулгүй байдал, чанарын удирдлагын газар болон Агаарын цэргийн командлал нь гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийн явцыг тогтмол хянаж, үнэлэлт дүгнэлт өгч ажиллана.

5.2. Гэрээний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх

5.2.1. Хоёр тал энэхүү гэрээний хэрэгжилтэд жилд 1 удаа дүн шинжилгээ хийж, үр дүнг харьяа дээд байгууллагад танилцуулна.

5.2.2. Дүн шинжилгээний явцад илэрсэн үл тохирлуудыг залруулах, дахин давтагдахаас урьдчилан сэргийлэхийн тулд шаардлагатай арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

5.3. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

5.3.1. Энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг талууд албан бичгээр харьяа дээд газарт хүргүүлэх ба гаргасан саналыг үндэслэн өөрчлөлт оруулна.

5.3.2. Аливаа маргаантай асуудлыг хоёр талууд харилцан зөвшилцөн хамтран шийдвэрлэнэ. Хэрвээ маргаан шийдвэрлэгдэх боломжгүй бол харьяа дээд газарт хандан шийдвэрлүүлнэ.

5.4. Харилцах хаяг, утас

5.4.1. Цахим хаяг болон утасны дугаар өөрчлөгдсөн тохиолдолд хоёр тал харилцан мэдэгдэнэ.

ХАРИЛЦАХ ХАЯГ, УТАСНЫ ЖАГСААЛТ.

АЛБА	АЖЛЫН БАЙР	УТАС
ИНҮТ ТӨХХК НХҮА	БУҮХ-ийн ээлжийн ЕНХУ	7128-1618 7004-7340
	ОУҮХ-ийн ээлжийн АНХУ	7128-1176 7128-1179
	“Чингис Хаан” АУБ-ны ЭЕНХУ “Буянт-Ухаа” АУБ-ны ЭЕНХУ	7128-7100 7128-1611
	НХҮА-ны НМТ-ийн “Арцат”	7128-1635
	ЭХАТАМЗТ Iridium (сансрын утас)	7128-1622 7128-1691 881623434732
	АБЧУГ	7128-3116 7128-1619 sqmd@ncac.mn safety-atc@ncac.mn
	АНҮГ	7128-3000 7128-3292 ncac_ansd@ncac.mn ansd@ncac.mn
	НУТА Нислэгийн цагийн хуваарь, зөвшөөрлийн хэсгийн- Орон нутгийн нислэг хариуцсан Нислэгийн урсгал төлөвлөлтийн мэргэжилтэн Шуурхай төлөвлөлтийн хэсгийн-Ээлжийн	 7128-2035

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨХХК
ХЯНАВ
Хуулийн мэргэжилтэн 3
20 . . . он . . . сар . . . өдөр

	Нислэгийн төлөвлөлтийн мэргэжилтэн	7128-1602
ИНҮТ ТӨХХК НМҮА	“Буянт Ухаа” аэродром дахь Шуурхай мэдээллийн хэсгийн нэгж	71283130 notam@ncac.mn
	“Чингис Хаан” аэродром дахь Шуурхай мэдээллийн хэсгийн нэгж	71287282 71287131 notam@ncac.mn
Агаарын цэргийн командлал Агаарын цэргийн Төв командын байр	51-262656 92090532 menen@mil.gov.mn	
	70152642 92115961	

5.5. НМҮБ болон АНҮГ-ыг түүхий өгөгдлөөр хангах томилогдсон ажилтнууд

5.5.1. Түүхий өгөгдлөөр хангах томилогдсон ажилтнуудад өөрчлөлт орсон тохиолдолд АНҮГ-ын Нисэхийн мэдээллийн үйлчилгээ, технологи үйл ажиллагаа хариуцсан ахлах технологич мэргэжилтэнд edavaasuren@ncac.mn цахим шуудангаар нэн даруй мэдэгдэнэ.

ТОМИЛОГДСОН АЖИЛТНУУДЫН ЖАГСААЛТ

Д/д	Овог, нэр	Албан тушаал	Цахим шуудан/Утасны дугаар
1	Д.Болор-Эрдэнэ	Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Цэргийн нисэхийн хэлтсийн нисэхийн ахлах офицер, шалгагч инженер	bboogii0817@gmail.com 99276819
2	Б.Цолмон	Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Цэргийн нисэхийн хэлтсийн нисэхийн шалгагч нисгэгч	tsoomoo.0650@gmail.com

ИНҮТ ТӨХХК-ийг төлөөлж:

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА

.....

Б.ХҮСЭЛТ

АГААРЫН НАВИГАЦИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА

.....

Д.БАЯРТОГТОХ

Агаарын цэргийн командлалыг төлөөлж:

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АГААРЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛЫН ЦЭРГИЙН НИСЭХИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

ХУРАНДАА Д.ШАТАРРАГЧАА

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АГААРЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛЫН УДИРДЛАГА ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН БЭЛЭН БАЙДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ ОФИЦЕР

ХУРАНДАА Э.ЭНХБАЯР

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АГААРЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛЫН ТӨВ КОМАНДЫН БАЙРНЫ ДАРГА

ДЭД ХУРАНДАА Б.АМАРСАНАА

“ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨХХК
ХЯНАВ
Хуулийн мэргэжилтэн 3
2026 он 04 сар 29 өдөр